

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ /ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛЭЭР/**

2019 оны 09 дүгээр сарын 04

Багануур дүүрэг


№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2019 онд хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ							
Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:							
21	1.10. Багануур үйлдвэрлэл, технологийн парк-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	1.10.1. Үйлдвэрлэл, технологийн парк ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулна.	БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	10%	7%	
		<p>1. 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг БХБЯ-ЗҮ-2017/011 дугаартай зөвлөх үйлчилгээний 2018/10 гэрээний дагуу Барилга хот байгуулалтын яамны захиалгаар “Мон Энержи Консалт” ХХК гүйцэтгэж эхэлсэн.</p> <p>Паркийн Ерөнхий төлөвлөгөөг 2019.08.02-нд НИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>2019.09 дүгээр сарын байдлаар Паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаан хангамжаас бусад бүх тооцоо судалгаа, зураглалын ажилбар 100% дууссан.</p> <p>Уг захиалгат ажлын гэрээний хугацааг 2019.06.28-ны өдрийн 2019/120 дугаартай нэмэлт, өөрчлөлт, сунгалтын нөхцөлөөр 2019.07.30-ны өдөр хүртэл сунгасан ч Мон-Энержи Консалт ХХК нь</p>					


		<p>дараах үндсэн шалтгаануудаар дуусгаагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Эрчим Хүчний сайдын цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтыг 2018.09.15 - 2019.03.01-ний өдрийг хүртэл түр зогсоох 134 дүгээр тушаал гарсан. - Паркийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2013 онд тухайн үеийн Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яам нь ЭХЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй тул техникийн нөхцөл олгох боломжгүйг мэдэгдсэн. - БХБЯ-ны хүсэлтээр Паркийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг ХХААХҮЯ-ны архиваас гаргуулж ЭХЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв. - Паркийн ТЭЗҮ-д тооцсон эрчим хүчний хэрэглээ нь Багануур дүүргийн цахилгаан хангамжийн хүчин чадлын нөөцөөс хангах боломжгүй байгаа тул паркийн төслүүдийг хэрэгжүүлэх үе шатанд хэсэгчлэн эрчим хүчний хэрэглээг тооцож холбохоор ЭХЯ-ны Эрчим хүч хангамжийн газартай зөвшилцөж байна. <p>Паркийн зүгээс зураг төслийн ажлыг ондоо багтаан дуусгахын тулд бүх талын бололцоот арга хэмжээг авч байна.</p> <p>2. Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 108,7 тэрбум төгрөгийг Паркийн ТЭЗҮ-д тусгагдсан тооцоог үндэслэн оруулж батлуулсан. Уг хөтөлбөрт 2019 оны 02 сард хийсэн тодотголын саналыг УУХҮЯ-ны ХҮГТГ, нийслэлийн ХБТГ-т хүргүүлж улмаар Үндэсний хөгжлийн газарт дээрх санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр уламжлав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2019 оны 33 дугаар захирамжаар батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.4.4.5-д “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийг ашиглалтад оруулах” гэсэн заалтыг үндэслэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын дунд хугацааны санхүүгийн тооцоог боловсруулж</p>		
--	--	---	--	--


		<p>265.81 тэрбум төгрөгийн /ерөнхий төлөвлөгөөний томсгосон тооцоогоор/ хөрөнгө оруулалтыг 2020-2025 онд хэсэгчлэн тусгах саналаа хүргүүлсэн.</p> <p>Үүний үр дүнд улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар паркийн дэд бүтцийг бүтээн байгуулахад 2020 онд шаардлагатай 59,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн тооцоог ЭХЯ, БХБЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ болон нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тус тус хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Цахилгаан хангамжийн агаарын шугам 110х35 2х25000 кВт дэд станц • Хүнд үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтэц • Хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтэц <p>Мөн БХБЯ нь улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтад паркийн 2020 оны хөрөнгө оруулалтын саналыг тусгаж Сангийн яаманд хүргүүлээд байна.</p>					
22	1.11. Эдийн засгийн үр ашигтай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана.	<p>1.11.1. Шинээр үйлдвэр байгуулах гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, мэдээллээр хангаж ажиллана.</p> <p>1. Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон Герман улсын GIZ ЭТИС хөтөлбөр хамтран “Инноваци 2019” төсөл сонгон шалгаруулалтыг зарласан тул паркийн зүгээс Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх, Багануур цахилгаан механикийн үйлдвэрээс гарах төмрийн хаягдал хэрчдэсээр бэлэг дурсгалын зүйл хийх, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооны элсээр зүлгүүр хийх, Хүүхдийн модон тоглоомын үйлдвэрүүдийн төслүүдийг боловсруулж хүргүүлснээс эхний 2 төсөл нь шалгарсан боловч эцсийн шалгаруулалтад тэнцээгүй болно. Харин 09 сард төсөл хэрэгжүүлэгч нарт зориулсан 3 өдрийн сургалтад 1 албан хаагчийг 100% хөнгөлөлттэй хамрагдах эрх авсан.</p> <p>2. Тус паркад үйлдвэр байгуулах саналтай дараах байгууллагуудын мэдээллийг хүлээн авч паркийн эрх зүйн байдал, эзэмшил газар, дэд</p>	ДБҮҮХ, БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	50%	50%	

		<p>бүтцийн нөхцөлийн талаар зөвлөгөө өгч харилцан санал солилцов.</p> <ul style="list-style-type: none"> - Нүүрсний химийн үйлдвэрийг байгуулах “Синкопа Монгол” ХХК - Багануурын уурхайн нүүрсээр тэсэлгээний бодис үйлдвэрлэх “Очир Ундраа” ХХК - Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Хемп Монгол” ХХК <p>3. “Монгол Минерал” ХХК, түүний түнш Герман улсын “PHARMAWERK” компанийн удирдлагуудад паркийн үйл ажиллагааг танилцуулан исэлдсэн нүүрсийг хүн болон мал эмнэлгийн эмчилгээнд ашиглах чиглэл, түүний нөөцийн асуудлаар санал солилцож Багануурын нүүрсний уурхайтай танилцуулав.</p>					
ГУРАВ. БАЯЛАГ БҮТЭЭГЧДЭЭ ДЭМЖСЭН, ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖСӨН ХОТ							
133	<p>3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд нано технологи, аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, томоохон болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.</p>	<p>3.1.1. Монхимо ХХК-ий Адуу брэндийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах ажлыг бодлогоор дэмжинэ.</p>	<p>БҮТП ОНӨТҮГ Монхимо ХХК</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100%	75%	
		<p>1. Ерөнхий сайд болон салбарын сайдуудыг Багануур дүүрэгт ажиллах хугацаанд Монхимо ХХК-ийн “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-т батлагдсан “Адуу” брэндийн үйлдвэрлэлийн өргөтгөлд шаардлагатай 5,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар асуудлыг танилцуулсан.</p> <p>2. Паркийн нэгж Монхимо ХХК нь Оросын холбооны улсад бүтээгдэхүүн экспортлох албан ёсны зөвшөөрлүүдийг хүлээн авч үйлдвэрлэлийн өргөтгөлийн ажилд бэлтгэж байна.</p>					
151	<p>3.10. Гадаадын хөрөнгө оруулалттай, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий ноос гүн боловсруулах эко үйлдвэрийн ажлыг дэмжиж эхлүүлнэ.</p>	<p>3.11. Гадаадын хөрөнгө оруулалттай, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий ноос гүн боловсруулах эко үйлдвэрийн ажлыг дэмжиж эхлүүлнэ.</p>	<p>БҮТП ОНӨТҮГ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	30%	0%	
		<p>1. Силк Роуд Аёори Япон ХХК-ийн төслийн баг 2018 оны 08 дугаар сард үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүхий эдийн үнийн өсөлт болон патентын төлбөрөөс шалтгаалан ноос, ноолуур гүн боловсруулах үйлдвэрийн төслөө буцаасан.</p>					

Дундаж хувь	69%	
-------------	-----	--

ТАЙЛАН ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА  Ч.ЭЛБЭГСАЙХАН



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Б.МИЧИД-ЭРДЭНЭ